

Бичгийн тигийг журамлахын учир

Г.Бямбацэрэн, Т.Энхтуяа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн сургууль,
Бага боловсролын монгол хэл, нийгмийн ухааны тэнхим

Хураангуй

Тигийн дагуу хичээнгүй бичиж сурах нь ямар хэрэгтэй вэ, сайхан бичих юунд хэрэгтэй вэ, заавал эндээс тэндээс эхэлж бичих ёстой гэдэг нь юунд хэрэгтэй вэ? гэх мэт асуулт бичиг үсэг эхлэн заагч, багш нар, судлаачдын дунд багагүй яригддаг. Бичгийн тиг ч өнөөдөр янз бүр байгаа нь үсэг нүдэлж унших чухалчлагдаж бичгийн хэлний анхдагч ойлголт тигийн дагуу бичихээс эхлээд зөв бичих хүртлээ асуудлын мөн чанарыг ухаараагүйд байдаг. Констуктист хандлагатай багш төрөлх чадамж болох хүүхэд өөрсдөө нээх, турших, бүтээх, юмыг салгах, сэгсрэх цохих зэргээр бодит ертөнцийн талаарх мэдлэгээ өөрсдөө бүтээх боломжийг нь бүрдүүлэн үсэг ямар зурлагуудаас бүтдэг, тэр зурлага өөр ямар үсгэнд байгаа, энэ зурлагыг өөрчилбөл өөр ямар үсэг болох зэргээр өөрсдөө үсгийн ертөнцөө нээхээр сургалтыг зохион байгуулахаас бичгийн тигд суралцдаг. 6 настай хүүхэд үсгийн тэмдэгт, янз бүрийн тэмдэг тэмдэглэгээний тухай ойлголттой ч тухайн ойлголтыг өөрийн болгох бодит үйл хийх шаардлагатай байдаг¹. Гэтэл 50 сургуулиас авсан судалгааны үр дүн дармал болон бичмэл үсгийн дүрсийг шууд нүдлүүлэх, цээжлүүлэхэд чиглэж, ингэхдээ буруу тиг цээжлүүлдгээс бичих чадвар төлөвших нь удаахрах, хурдан бичихэд муугаар нөлөөлдөг байна. Гэтэл бичгийн тиг, тэр ч бүү хэл баруунаас зүүн тийш бичих, дээрээс доош бичихэд хүртэл хүний сэтгэх чадвар, оюуны ухааны хөгжилд нөлөөлдөг ажээ. 1987 онд бичгийн хурд, сэтгэх хурдын хамааралд үндэслэн бүх үсгийн холбоосыг доороос холбохоор тогтоосны² учрыг үл ухаарснаас судалгаанд хамрагдсан багш нарын 48 % нь буруу холболтоор үсгийн тигийг зааж байна. Тиймээс үсэг бичих тигийг журамлах, арга зүйг шинэчлэх нь чухал болно.

Түлхүүр үг

Үсэг, зурлага, хурдан бичих, холбоос, арга зүйн шинэчлэл

Хэл ярианд суралцахуй нь танин мэдэхүйгээс хамааралтай. Хэл яриа гэдэг нь ярих ойлгох, унших, бичих бөгөөд аяндаа уншиж бичих сурах нь хэл ярианы хөгжлийн нэгдмэл (holistic) багцад хамаардаг ойлголт. Судлаачид бүр багаас нь хэл яриатай холбоотой хийлгэж байгаа бүхий л үйл ажиллагаанууд уншиж бичиж сурах үйлийн нэг хэсэг. Хүүхдийн ярианы чадвар нэмэгдэхийн хэрээр уншиж бичихэд дөхөм гэж үздэг. Халуун дулаан харилцаа нь аюулгүй мэдрэмжийг өгснөөр тархины хөгжилд чухал бөгөөд энэ нь эргээд бага насны хүүхдийн унших бичих чадварын хөгжилтэй холбогддог (Gonzalez-Me-na.J, 2006). Яриа авиаг цаасан дээр тэмдэгтээр илэрхийлж болдог гэдгийг ойлгох нь хүүхдийн хувьд сэтгэл хөдөлгөсөн агшин гээд бид бичиж сурахад бэлтгэл үйлийг хэр хийдэг, хэр мэддэг билээ гэдэг асуудал гарч ирж байна.

Гэтэл бидний уламжлалт сургалт сургуульд орох бол сурах хэрэгцээг мэдрүүлэх хэмээн үүнийг чухалчилснаас үүдэн бичихэд тусгай цаг гарган “хүчээр” үсэг заагаад уншихын зэрэгцээ бичгийн хэлэнд сургах үйлийг нэг зэрэг хийдэг. Хийхдээ багш бүр хүүхдэд биш өөртөө хялбар


байдлаар зохион байгуулалт хийдэг.

Суралцагч маань багшаас ялгаатай байдлаар төлөвлөх, бичихэд бэлэн байдлыг тодорхойлох, сурах үйлийн онолын үндсийг өөрөөр харах, суралцагчийн хөгжлийн ойрын хөгжлийн бүсэд хэрхэн нэвтрэх гээд олон зүйлийг шаардаж байна.

Тиймээс бид хүүхдийн төрөлх чадамж болох хүүхэд өөрсдөө нээх, турших, бүтээх, юмыг салгах, сэгсрэх цохих зэргээр бодит ертөнцийн талаарх мэдлэгээ өөрсдөө бүтээх боломжийг нь бүрдүүлэн үсэг ямар зурлагуудаас бүтдэг, тэр зурлага өөр ямар үсгэнд байгаа, энэ зурлагыг өөрчилбөл өөр ямар үсэг болох зэргээр өөрсдөө үсгийн ертөнцөө нээхээр сургалтыг зохион байгуулахаас бичгийн тигд суралцдаг. 6 настай хүүхэд үсгийн тэмдэгт, янз бүрийн тэмдэг тэмдэглэгээний тухай ойлголттой ч тухайн ойлголтыг өөрийн болгох бодит үйл хийх шаардлагатай байдаг зэргээс үүдэн бичих үйлийг хөтөлж буй сургалтын арга зүй, хүүхдийн бичих үйлд сурах зэргийг судаллаа.

✉ byatsrn@gmail.com

Судалгааны зорилго багшийн бичих үйлийг дэмжиж хөгжүүлж байгаа аргыг судлах, энэ нь суралцагчийн бичих хөгжилд ямар нөлөөлөл үзүүлж байгааг илрүүлэх, 6 настай суралцагч бичих үйлд хэр бэлтгэгдсэн байдаг, бичгийн тигийг журамлах, журамлахын мөн чанар 6 настай суралцагчид хамаатай эсэхийг тодруулах. Бичих үйлийн орчин ямар байгааг доорх шалгуурыг баримтлан ажиглалт хийлээ.



Судалгааг 50 сургуулийн багш, хүүхдийг хамруулж хийсэн.

6 настай суралцагч нэг бүртэй идэвхтэй яриа өрнүүлэхийн зэрэгцээ унших, бичих зан үйлийг үлгэрлэх, уншиж бичихийн хөгжилтэй, зугаатай тал болон үүнд чиглэсэн сонирхлыг нь дэмжин хөгжүүлэх хэрэгтэй. Бичиж сурах нь шинэ санаа бүтээх, бичиж сурах шинэ арга олоход оршино. Үүний тулд үсэг бүтээх зурлагыг хэлж өгөөд үсгийг шууд бичүүлж сургахын оронд сэтгэхүйн бүтээлч үйл болгон хөгжүүлбээс хүүхдийн нас сэтгэхүйд тохирохын зэрэгцээ сургалтад оролцоог эрхэмлэх, хүүхдийн бие даасан байдлыг дэмжих, танин мэдэхүй бол хэл, нийгэмшихүйн чадамжийг дэмжих арга зүй болох юм.

- Эвлүүлэх (агглютинация) нь хэд хэдэн зурлагыг эвлүүлэн шинэ санаа, шинэ үсэг бүтээх, шинэ санаа олох
- Төсөөтэй болгох(аналогия) нь өөр өөр зүйлийн төсөөтэй шинжийг олоход тулгуурлан өөр өөр үсгийн төстэй шинжийг олох, үсгийн төсөө үүсгэх,
- Онцлон ялгах (акцентирование) нь олон шинжээс аль нэгийг ялгах, тухайн үсгийн зурлагын онцлог шинжийг тодорхойлох
- Ерөнхийлөх (типизация) нь тухайн юмны хэв шинийг тогтоох, олонтоо давтагдах дэлгэрэнгүй гол шинжийг олох, үсгүүдийг түгээмэл шинжээр бүлэглэж ангилах
- Ихэсгэх ба багасгах (преувеличение и преуменьшение) Үсгийн өөр хэлбэрийг тухайлбал, дармал том жижиг үсгийг, бичмэл харьцуулах, үсгийг зурах, бичих үйлтэй хослуулах гэх мэтээр сэтгэхүйн үйлд

тулгуурлан бодит сэтгэхүйн ойг хийсвэр сэтгэхүй болгоход дагуулан хөгжүүлэх атал 3-аас доошгүй мөр хуулан бичихээр бичих үйлийн хөгжлийг дэмждэг арга зүй зонхилохын зэрэгцээ бичих үйл ямар идэвхгүй үйлээр үргэлжилдэг болохыг судалгаа харуулсан.

Судалгаанд хамрагдсан багш нарын 57,8 % нь үсгээ хуулж бичихийн зэрэгцээ үсгийн төсөө үүсгэдэг. Багш өөрөө үсэг бүтээх зурлагаа зөв таньж хувиргах дасгал сайн хийдэг байх. Үүний тулд дараах судалгааг авсан болно.


Хүснэгт 1

я, ы, ц үсгийг бүтээх зурлагыг таниулж буй аргын хэрэглээг багшийн тоогоор үзүүлбэл:




Хүснэгт 2

Т, Б, В, Г, С үсгийн зурлагыг зөв танихыг хувиар үзүүлбэл:



Хүснэгт 3

а, б үсгийг бичих аргачлал




Дээрх графикаас харахад багшийн бичих чадвар сурагчид шууд нөлөөлж байгааг харж болно. 1959 онд боловсруулагдсан Б.Цэвэгжавын “Цэвэр бичиг” номоор кирилл бичгийн тиг угалзруулан даралттай бичиж байснаа 1972 онд өөрчлөгдөн элдэв угалз, даралт, цэг цэглэлийг

хасаж зурлагуудыг энгийн болгожээ. Энэ үед Б.Сэмжидийн 1970 онд гарсан “Хичээнгүй бичиг заах гарын авлага”, 1972 онд бичигдсэн С.Шаравын “Хичээнгүй бичиг” гэсэн ном, гарын авлагыг эх сурвалж болгон ашиглаж ирсэн байна. 1987-1988 оны хичээлийн жилд 7 настай хүүхэд сургуульд орохын учир хичээнгүй бичгийн тиг дахин шинэчлэгдсэн бөгөөд дээр доор дундаас холбодог гурван төрлийн холболт, үсгийн эхлэлийг цэгцлэн бүх жижиг үсгийг доороос холбох, эхлэх (а, о, ь, ь, в,б, э, ө), үзэг салгалгүй бичдэг байсныг үзэг салгах (А, Д) зэрэг шинэчлэлийг Г.Лхаахүү, Ч.Жачин нар хийсэн байна. Гэтэл хичээнгүй бичгийн хөгжлийн явцад хийгдсэн шинэчлэл багш нарт хийгддэггүй бөгөөд өөрсдийнхөө сурснаар бичүүлж сургадаг.


Хүснэгт 4

Судалгаанд хамрагдсан багшийн нас



Хүснэгт 5

Ахмад багш нарын холболт, үсэг, зурлагыг тодорхойлсон байдал




6 настай хүүхдийн унших хурд багшаас хамааралтайг 2017 хийгдсэн үндэсний хэмжээний судалгааны дүн харуулдаг бөгөөд энэхүү судалгааны явцад 5 үгтэй нэг өгүүлбэр цээжээр бичүүлэхэд үгийг зөв бичихүйн гүйцэтгэл уншихаас хавьгүй их. Харин холболт, бичгийн хэв янз бүр байсан. Үүнийг бид орхихгүй байх бөгөөд бичих хурдад янз бүр заасан явдал нөлөөлдөг болохыг тэдний бичгийн хурд харуулдаг. Хүний бичгийн хэв шилжилтийн нас буюу 10-12 насанд төлөвших бөгөөд энэхүү хэв хүний насан туршийн бичгийн хэв болж тогтдог. Үүнээс үзэхэд бичгийн тигт суралцах үйл 6-8 жил үргэлжилдэг болохыг судлаачид тогтоосон байдаг ба тогтоосон бага анги бол бичгийн хэлний суурь билээ. Тиймээс судлагдаад тогтоосон тигийг багш бүр ягштал барьдаг байх. Тухайлбал: бүх жижиг үсгийг доороос холбох нь 6 настай хүүхдийг самууруулахгүй байх, хурдан бичиж сурахад шууд нөлөөлдөг болохыг баталсан. Аль ч хэлэнд зөв бичихүйн асуудал үсгийн тиг(элемент)-ээс эхлэх бөгөөд Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын дүрэм

зохиогдох тэр үед хамгийн сүүлийн үсгийн тигийн өөрчлөлт хийгдсэн байна. 6 настай хүүхдийг бичүүлж сургахад янз бүрээр тигийг заахын зэрэгцээ зурлагыг мэдлэг бүтээх сургалтын арга зүй болгож ашигладаггүй, хүүхдийн оролцоог дэмжсэн үйлд хөтөлдөггүй зэргээс хамаарч бичих үйл залгаа шинжтэй, идэвхгүй, хуучин арга зүй байгааг судалгаа харуулна.

Хүснэгт 6

6 настай хүүхдийн гүйцэтгэл



Харьцуулсан судалгааг авч үзье



Дүгнэлт

6 настай хүүхдийн бичих үйлийг дэмжих арга зүйн шинэчлэл хийх, улмаар үсгийн тигийг шинэчлэх, доороос холбодог аргачлалыг түгээн дэлгэрүүлэх нь чухал. Судалгаанд суурилсан бичгийн тигийг мөрдөх. Үүний тулд үсгийн тигийн дагуу бичгийн хэлэнд системтэйгээр сургах. Бичих үйлийн бэлтгэл болгож бэлэн байдлын ялгаатай сурах үйлийг сургуулийн өмнөх боловсролын агуулгад төлөвлөдөг байх.

Ном зүй

- Жачин, Ч. (2014). Багшаас суралцсан он жилүүдийн бичээс. Улаанбаатар
- Жанет Гонзалес Мена. (2011). Соёлын баялаг, ялгаатай орчинд багшлах нь. Орч: Д.Наранцэцэг нар.
- Лхаахүү, Г. (2015). Хичээнгүй бичиг заах арга зүйн зөвлөмж. Улаанбаатар
- Санжаа, Ж. (2011). Авиа авиалбар их авиалбар. Улаанбаатар
- Цэвэгжав, Б. (1959). Цэвэр бичиг. Улаанбаатар
- Шарав, С. (1972). Хичээнгүй бичиг. Улаанбаатар
- Rhonda Bondie. All Learners Learning Every Day, <http://alled.org>